



## БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2026 оны 06 сарын 11 өдөр

Дугаар А/421

Булган сум

### Шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх яаралтай дархлаажуулалт зохион байгуулах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 8 дүгээр зүйлийн 8.4, 9 дүгээр зүйлийн 9.1, 9.4, 9.5, 9.6, 9.7 дахь хэсэг, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1 дахь заалт, Засгийн газрын 2018 оны “Мал, амьтны гоц халдварт, халдварт өвчний жагсаалт батлах тухай” 225 дугаар тогтоол, Мал эмнэлгийн ерөнхий газрын даргын 2026 оны 06 дугаар сарын 11-ний өдрийн “Шүлхий өвчнөөс сэргийлэх яаралтай дархлаажуулалтын ажлыг зохион байгуулах тухай” А/163 дугаар тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Сайхан сумын Мануулт багт малын гоц халдварт шүлхий өвчин оношлогдсон тул голомтын болон сэжигтэй бүсийн тугал, бог малыг шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх яаралтай дархлаажуулалтад хамруулах ажлыг 2026 оны 06 дугаар сарын 12-ны өдрөөс эхлэн 7 хоногийн хугацаанд шуурхай зохион байгуулсугай.

2. Яаралтай дархлаажуулалтад хамруулах малын тоо, шаардагдах вакцины хуваарийг хавсралтаар баталсугай.

3. Яаралтай дархлаажуулалтад шаардагдах вакцин, био бэлдмэлээр хангаж сумын мал эмнэлгийн үйлчилгээний нэгжийг мэргэжлийн удирдлага, арга зүйгээр хангаж ажиллахыг Мал эмнэлгийн газар (Г.Одсүрэн), орон нутагт зохион байгуулж удирдлага, хүн, хүч, техник хэрэгсэл, шатахуун бусад шаардлагатай зүйлээр хангаж ажиллахыг Сайхан сумын Засаг дарга (М.Ганболд)-д тус тус үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Д.ПҮРЭВ-ОЧИР

06  
А/421  
Аймгийн Засаг даргын 2026 оны  
дугаар сарын М.-ны/ний өдрийн  
дугаар захирамжийн хавсралт



ШҮЛХИЙ ӨВЧНӨӨС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ  
ДАРХЛААЖУУЛАЛТЫН ХУВААРЬ

д/д	Сумын нэр	Нэр төрөл			Шаардагдах вакцин	Аймгийн нөөцөд байгаа үлдэгдэл вакцин
		Тугал	Бог	Нийт	Тун	Тун
1	2	3	4	5	6	7
1	Сайхан	611	30,700	31,311	15,961	16,050

--o00o--